

ТӨРИЙН АЛБА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР ТӨВ АЙМГИЙН ИРГЭДЭЭС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮНГИЙН ТУХАЙ

2011.01.16

Зуунмод

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 11 үгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу төр засгийн бодлого шийдвэр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа болон төрийн алба үйлчилгээний байдалд дүгнэлт өгөх зорилгоор аймгийн насанд хүрсэн нийт иргэдийн 5 хүртэл хувийг хамруулав.

Санал асуулгыг Хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын болон аймгийн Засаг даргынүйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд өгөх дүгнэлт, төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар үр дүн гэсэн 4 бүлэг асуудлын хүрээнд 2011 оны 1 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд “Бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын жил”-ийн ажлын нээлтийг 27 суманд зохион байгуулах санамсаргүй түүврийн аргаар авлаа.

Санал асуулганд 2033 иргэн оролцсоноос насны байдлыг доорх графикаар үзүүлэв.



Боловсролын байдал	тоо	Эзлэх хувь
Дээд	607	29.86
Тусгай дунд	410	20.17
Бүрэн дунд	548	26.96
Бүрэн бус дунд	390	19.18
Боловсролгүй	78	3.84

1. Хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэрийн хэрэгжилтийн талаар санал асуулганд оролцсон иргэдийн 915 буюу 45.0% нь бүрэн хангалттай, 965 буюу 47.5% нь хангалттай, 92 буюу 4.5% төдийлөн хангалттай бус, 51 буюу 2.5% нь хангалтгүй, 10 буюу 0.5% нь мэдэхгүй гэж дүгнэв.

Тус үзүүлэлтийн хүрээнд иргэд хууль эрх зүйн мэдээлэл сурталчилгаа сайн хийгдэж байна, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажил боломжийн байна гэж үзсэн бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнд хүргэх шаардлагатай байна гэж дүгнэсэн.

2. Засгийн газрын болон аймгийн Засаг даргынүйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар оролцогсдын 1071 буюу 52.7% бүрэн хангалттай, 823 буюу 40.5% хангалттай, 78 буюу 3.8% төдийлөн хангалттай бус, 49 буюу 2.4% нь хангалтгүй, 12 буюу 0.6% нь мэдэхгүй гэж дүгнэсэн байна.

Төрөөс иргэдэд үзүүлж байгаа нийгмийн халамжийн үйлчилгээ, газар тариалангийн үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанууд сайн хийгдэж байна, харин байнгын ажлын байр боловсруулх орлого нэмэгдүүлэх, амьжиргааг дэмжих, үнийн өсөлттэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна гэж үзсэн.

3. Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар 1084 буюу 53.3% нь онц, 808 буюу 39.7% нь сайн, 81 буюу 4.0% нь дунд, 52 буюу 2.6% нь муу, 8 буюу 0.4% нь мэдэхгүй гээд

төрийн байгууллагуудаас цэцэрлэг, сургууль, эмнэлэг, ЗДТГ-ын үйл ажиллагааг боломжийн ажиллаж байна гэж дүгнэсэн бол мал эмнэлэгийн үйл ажиллагааг хангалтгүй гэж дүгнэв.

4. Үйлчилгээний талаар 888 буюу 43.7% нь онц, 1024 буюу 50.4% нь сайн, 78 буюу 3.8% нь дунд, 37 буюу 1.8% нь муу, 6 буюу 0.3% нь мэдэхгүй гэж дүгнэлээ.

Халамжийн үйлчилгээ, ундны усны хангамж, сумын төвийн тохижилтын хүрээнд хийж буй ажлууд боломжийн, харин бэлчээр усжуулалт, нийтийн ахуйн үйлчилгээний талаар анхаарах шаардлагатай гэж дүгнэлээ.

Дээрх дүгнэлтүүдийг үндэслэн судалгааны дүнг нэгтгэхэд Хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэрийн хүрээнд 4.34, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 4.42, өрийн байгууллагын үйл ажиллагаа 4.43, үйлчилгээний үр дүн 4.35 буюу дөрвөн хэсгийн дундаж үнэлгээ **4.4**

ТӨВ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА

Р.БОЛД